



НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

20 20 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/328

Улаанбаатар хот

“Бичил өргөө” сууц өмчлөгчдийн
холбоонд байр нэмж гэрчилгээ шинээр
олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.л, 29.2, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянгол дүүргийн 12 дугаар хорооны 23а, 36 дугаар байрны оршин суугчдын бүх гишүүдийн хурлын шийдвэрээр “Бичил өргөө” сууц өмчлөгчдийн холбоонд нэгдэхээр холбогдох материалыг ирүүлснийг үндэслэл болгон “Бичил өргөө” сууц өмчлөгчдийн холбооны харьяалалд нэмж бүртгэж, гэрчилгээ шинээр олгох ажлыг зохион байгуулсугай.

2. Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн хэвийн байдлыг хангах, сууц өмчлөгчдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, дундын өмчлөлийн эд хөрөнгийн эзэмшил, ашиглалт, хамгаалалтыг эрхлэн хариуцах, биелэлтийг ханган ажиллахыг “Бичил өргөө” сууц өмчлөгчдийн холбоонд үүрэг болгосугай.

3. Дүүргийн сууц өмчлөгчдийн холбоодын бүртгэлд нэмж бүртгэх, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс /Т.Мөнгөтулга/-т даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан “Бичил өргөө” сууц өмчлөгчдийн холбооны 2010 оны 02 дугаар сарын 22-ны 04 дүгээр гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



С.ОДОНТУЯА